



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр
Хурал хуралдсан газар: АСЕМ цогцолборын хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-гийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурьдсан 8 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлтэй Удирдах зөвлөлийн гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.

Хоёрдугаар асуудал. Монголын МСС-гийн 2021 оны гүйцэтгэлийн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилттэй танилцав.

Гуравдугаар асуудал. Монголын МСС-гийн Мэдээлэл харилцааны стратегийн төслийг хэлэлцэж батлав.

Дөрөвдүгээр асуудал. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн нэгдсэн төлөвлөгөөний төсөлтэй танилцав.

Тавдугаар асуудал. Монголын МСС-гийн 2021.10.01-нээс 2022.09.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.

Зургаадугаар асуудал. Монголын МСС-гийн 2021 оны 4 дүгээр улирлын санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.

Долдугаар асуудал. Монголын МСС-гийн Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж батлав.

Наймдугаар асуудал. Мэдээлэл харилцааны стратеги боловсруулалт, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон Хүний нөөцийн удирдлагад хийсэн дотоод аудитын дүнтэй танилцав.